



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 41

Мандалговь

Аймгийн Засаг даргын тамгын газрын  
өөрийн өмчийн орон сууцны түрээсийн  
төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 7 дугаар тогтоолын 8 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууцны 1 м.кв талбайн түрээсийн төлбөрийн жишиг үнийг 2000 төгрөгөөр тогтоосугай.

Хоёр. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Л.Доржбат)-д даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ